



**МОНГОЛ УЛСЫН
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
САЙД**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Нэгдсэн Үндэстний гудамж 5/2, Засгийн газрын II байр,
Утас: 26 28 30, 26 61 71, Факс: (976-11) 32 09 43,
E-mail: contact@mne.gov.mn, http://www.mne.mn

2018. 11. 13 № 01/8018
танай _____-ийн № _____-т

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН Л.МӨНХБААТАР ТАНАА

Таны ирүүлсэн 2018 оны 10 дугаар сарын 02-ны
өдрийн "Асуулга тавих тухай" 42 тоот албан бичигтэй
танилцаад тайлан, дүгнэлт, цаашид хийж хэрэгжүүлэх
арга хэмжээний санал зэргийг боловсруулан
хавсралтаар хүргүүллээ.

Хавсралт ²⁴.....хуудастай

Хувийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт



Н.ЦЭРЭНБАТ

102125

АСУУЛГА

1. Хөвсгөлийн байгалийн цогцолборт газарт ямар нөхцөл, шаардлага, журмын дагуу, хэрхэн газар ашиглах эрх олгож байгаа талаар:

Хариулт:

“Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль” 1994 онд батлагдан гарсан бөгөөд 33 дугаар зүйлийн 33.1-т “Дархан цаазат газрын болон байгалийн цогцолборт газрын хязгаарлалтын бүс, байгалийн нөөц газар, дурсгалт газраас Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад тодорхой зориулалт, хугацаа, болзолтойгоор байгаль орчинд сөрөг нөлөөгүй арга, хэлбэрээр гэрээний үндсэн дээр ашиглуулж болно”, мөн хуулийн 36 дугаар зүйлийн 36.1-т “Төрийн захиргааны төв байгууллага нь дархан цаазат газрын болон байгалийн цогцолборт газрын хязгаарлалтын бүс, байгалийн нөөц газар, дурсгалт газраас иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар ашиглуулах тухай шийдвэрийг хамгаалалтын захиргаа болон сум, дүүргийн Засаг даргын саналыг үндэслэн гаргана” гэж тус тус заасан. Энэ хүрээнд Байгаль орчны сайдын /хуучнаар/ 2001 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 218 дугаар тушаалаар “Тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглах зөвшөөрөл олгох түр журам” батлагдсан гарсан.

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийг батлан гаргаснаас хойш тус хуульд нийт 13 удаа нэмэлт, өөрчлөлт орсон боловч тэдгээр нь бусад хууль батлагдахад дагалдаж гарах өөрчлөлтийн хүрээнд хийгдсэн, уг хуульд зарчмын шинжтэй өөрчлөлт хийгдэлгүйгээр 24 жил болжээ. Мөн 1997 онд Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хууль батлагдсан боловч, төсөв санхүү, удирдлага, тогтолцооны хувьд учир дутагдалтай, тусгай хамгаалалттай газар нутгаас салгасан зэргээс хэрэгжилт хангалтгүй байна.

Энэ хугацаанд манай улс байгаль орчны чиглэлийн олон улсын хэд хэдэн конвенцид нэгдэн орж, Улсын Их Хурлаас байгаль орчны багц хуулиудыг 2012 онд шинэчлэн баталсан. Энэ шинэчлэлийн хүрээнд тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийг дэлхийн жишиг, зах зээлийн түгээмэл зарчимд тохируулан зохион байгуулах, түүний хэрэгжилтийг хангах, тогтвортой санхүүжилтийн шинэлэг арга,

механизмуудыг нэвтрүүлэх, удирдлага, зохион байгуулалт, боловсон хүчний чадавхыг шинэ түвшинд гаргах, аялал жуулчлалыг тогтвортой хөгжүүлэх, тусгай хамгаалалттай газар нутгийн экосистемийн үйлчилгээний эдийн засгийн өгөөжийг дээшлүүлэх, байгалийн нөөцийг тогтвортой ашиглах, нөхөн сэргээх, байгаль хамгаалах үйл ажиллагаанд орон нутгийн засаг захиргаа, иргэдийн нөхөрлөл, аж ахуйн нэгж, мэргэжлийн болон төрийн бус байгууллагын хамтын оролцоог хангах зэрэг зарчмын дорвитой шинэчлэл хийгдээгүй.

Иймд Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.2.1-т “Байгалийн унаган төрхөө хадгалсан газар, цэнгэг усны нөөц, томоохон гол мөрний урсац бүрэлдэх эхийн 50-иас доошгүй хувийг улсын тусгай хамгаалалтад авна”, 4.2.2-т “Тусгай хамгаалалттай газар нутаг түүний орчны бүсийн менежментийн эрх зүйн зохицуулалтыг шинэчилж байгальд ээлтэй аялал жуулчлал, ногоон хөгжлийн түшиц газар болгон хөгжүүлнэ” хэмээн тус тус тодорхойлж, Монгол Улсын Их Хурлын 2017 оны 11 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 29-д “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”, “Ногоон хөгжлийн бодлого”, “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” зэрэг төрийн бодлогын баримт бичигт “Байгалийн унаган төрхөө хадгалсан газар усны нөөц, гол, мөрний урсац бүрэлдэх эхийн 50-аас доошгүй хувийг улсын тусгай хамгаалалтад авч, улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг 2020 онд нийт нутаг дэвсгэрийн 25 хувьд хүргэнэ” гэсэн зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийг шинэчлэн найруулахаар заасны дагуу Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах хэрэгцээ, шаардлагыг Хууль тогтоомжийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсгийг үндэслэн урьдчилан тандан судалж, хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулаад байна.

Мөн Байгаль орчны сайдын /хуучнаар/ 2001 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 218 дугаар тушаалаар батлагдсан “Тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглах зөвшөөрөл олгох түр журам”-ыг шинэчлэн төсөл сонгон шалгаруулалтын үндсэн дээр нээлттэй явуулах зарчмыг баримтлан журмын төслийг шинэчлэн боловсруулсан.

Түүнчлэн “Газар ашиглах эрхийн гурвалсан гэрээ”-ний загварыг шинэчлэн боловсруулж, шинээр 15 өргөдлийн маягтыг гарган Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн А/378 дугаар

тушаалаар батлуулан нийт Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаад, сум, дүүргийн Засаг дарга нарт хүргүүлэн үйл ажиллагаандаа мөрдлөгө болгон ажиллахыг чиглэл болгосон. Үүнтэй уялдуулан Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн А/130 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар “Газар ашиглах эрхтэй холбоотой өргөдлийн дотоод танилцах хуудас”-ыг батлуулан Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаадад 2017 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 10/2953 тоот албан бичгийг хүргүүлж үйл ажиллагаандаа мөрдлөгө болгон ажиллах чиглэлийг өгсөн байдаг.

Дотоод танилцах хуудас батлагдан гарсанаас хойш өнөөдрийг хүртэл тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаад үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байгаа ч тухайн хуудсыг хууль тогтоомж, журам, стандартын хүрээнд дэлгэрэнгүй бөглөхгүй, анх батлагдан гарсан загварыг өөрчлөх, ёс төдий бичилт хийх зэрэг нийтлэг зөрчил байсан.

Тухайлбал газар ашиглалт ихтэй зарим хамгаалалтын захиргааны дарга, мэргэжилтнүүд дотоод танилцах хуудсыг дутуу бөглөх, асуудал хариуцсан хүний өмнөөс бичилт хийн гарын үсэг зурах, иргэн, хуулийн этгээдийн газар ашиглах хүсэлттэй холбоотой хэдэн хуудас материал хүлээн авсан бүртгэл, нутгийн иргэдийн саналыг авсан эсэх, аялал жуулчлалын стандартад тухайн төсөл нийцэж байгаа эсэх, кадастрын мэдээллийн санд орц гарц, зам хаах эрсдэлтэй, өндөр хүчдлийн шугам, дэд бүтэц, инженерийн шугам сүлжээ бүхий газар, гол, ус, ойн сан бүхий газрын хамгаалалтын бүсийн дэглэм зөрчиж буй эсэх зэрэг хууль тогтоомж, стандартыг үндэслэн дэлгэрэнгүй бичилт хийхгүй, ирүүлж буй газар ашиглуулах тухай санал нь “ДАВХЦАЛГҮЙ” гэсэн байдлаар ирж байгаа нь хууль тогтоомжийг зөрчих, газрын зөрчил, маргааныг гаргах нөхцлийг бүрдүүлж байсан. Үүнд анхааран “Газар ашиглах эрхтэй холбоотой өргөдлийн дотоод танилцах хуудас”-ын загварт өөрчлөлт оруулан нэрийг “Газар ашиглах эрхтэй холбоотой өргөдлийн дотоод хяналтын хуудас” гэж өөрчлөн хамгаалалтын захиргаадыг нэгдсэн удирдлагаар хангах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг бүрэн хангуулах, газрын зөрчил, маргаанаас урьдчилан сэргийлэх шаардлагын үүднээс хяналтын хуудсыг хууль тогтоомжийн хүрээнд хэрхэн бичилт хийх тухай аргачилсан зааврын төслийг боловсруулан баталсан.

Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 78 дугаар тогтоолоор батлагдсан “Бүртгэл мэдээллийн нэгдсэн тогтолцоог бий болгох Үндэсний хөтөлбөр”, Монгол

Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн Газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний /2.81.13/-д аймаг, нийслэлийн газрын кадастрын мэдээллийн санг солбицол, өндөр, тусгагийн нэгдсэн тогтолцоонд шилжүүлж, засварлан, Улсын кадастрын нэгдсэн системд холбож, үйлчилгээнд нэвтрүүлэх ажлын хүрээнд кадастрын мэдээллийн сангийн Лэнд менежер програм хангамжийг нэвтрүүлэх, Улсын кадастрын мэдээллийн сангийн нэгдсэн систем байгуулах ажлыг тус тус зохион байгуулахаар Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газартай хамтран ажиллаж байна. Энэ хүрээнд мэдээллийн сангийн стандартыг тусгай хамгаалалттай газар нутгийн онцлогт тохируулан боловсруулснаас гадна тусгай хамгаалалттай газар нутаг дээрх аялал жуулчлалын зориулалтаар газар ашиглах эрх авсан иргэн, хуулийн этгээдийн мэдээллийг засварлах ажлууд хийгдэж байна. Энэ программ хангамжийг нэвтрүүлснээр Монгол Улсын хэмжээнд нэгдсэн нэг стандартад суурилсан мэдээллийн сан үүсэж, салбар дундын уялдааг хангасан орон зайн мэдээллийн дэд бүтцийн систем байгуулагдах ач холбогдолтой.

Дүгнэн хэлэхэд хууль, газар ашиглах журам, гэрээ, өргөдлийн маягтууд, мэдээллийн сангийн стандарт, мэдээллийн санг ажиллуулах журам, аргачилсан заавар, стандарт зэрэг Тусгай хамгаалалттай газар нутгийн холбогдох хууль эрх зүйн баримт бичиг бүгд шинэчлэгдэн Лэнд менежер программ хангамжид орж системчлэгдэн иргэн, хуулийн этгээд өргөдөл өгөхөөс эцэсийн шийдвэр гарах хүртэлх бүхий л процесс, үйл ажиллагаа нээлттэй, түргэн шуурхай, хүртээмжтэй болох бөгөөд аялал жуулчлалын зориулалтаар газар ашиглуулахдаа төсөл сонгон шалгаруулах, нутгийн иргэдийн саналыг тусгах замаар олон нийтэд нээлттэй, ил тод байх зарчмыг баримтлан ажиллаж байна.

2. Хөвсгөлийн байгалийн цогцолборт газарт хамаарах Алаг-Эрдэнэ сүм, Хатгал тосгон, Ханх сумын нутаг дэвсгэрт тус яамнаас олгосон одоо хүчин төгөлдөр байгаа газар ашиглуулах эрх, хилийн зааг, газар ашиглуулах эрх дуусах хугацаатай холбоотой судалгаа:

Хариулт:

Хөвсгөлийн байгалийн цогцолборт газар нь 1992 оны Улсын бага хурлын 11 дүгээр тогтоолоор Улсын тусгай хамгаалалтад орж, 1995 оны Улсын Их хурлын 26 дугаар тогтоолоор Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд нийцүүлэн байгалийн цогцолборт газрын ангилалд хамруулсан. Тэр үед 837874 га талбайтай байсан бөгөөд 2011 оны Улсын Их хурлын 18 дугаар тогтоолоор 326900 га

талбайгаар газар нутгийг өргөтгөхдөө Ханх сумын 5960 га газрыг, Хатгал тосгоны 1470 га газрыг тусгай хамгаалалттай газрын хил заагаас гарган нийт 1175602 га газар нутгийг хамарч байна.

Хөвсгөлийн байгалийн цогцолборт газарт Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас аялал жуулчлалын зориулалтаар газар ашиглах эрх олгосон газрын судалгааг хүснэгт 1-ээр хүргүүлэв.

3. Газар ашиглах эрхтэй холбоотойгоор болон тусгай хамгаалалттай газар нутагт ажиллаж, амьдрахтай холбоотой асуудлаар орон нутгийн иргэдээс ирүүлсэн санал, гомдол, өргөдөл, хүсэлтүүд, тэдгээрийг хэрхэн шийдвэрлэсэн талаар:

Хариулт:

Хөвсгөлийн байгалийн цогцолборт газрын орчны бүсийн 5 сум, 1 тосгоноос өвөлжөө, хаваржаа, намаржаа, зуслан, гэр буудлын зориулалтаар хууль зөрчин олгосон газруудад нутгийн иргэд болон бусад орон нутгийн иргэд аялал жуулчлал эрхэлж байгаа бөгөөд сүүлийн жилүүдэд яамнаас хяналт шалгалт хийсний үр дүнд Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд хандан байгаль орчны нөлөөллийн ерөнхий болон нарийвчилсан үнэлгээ хийлгэх, зөвшөөрөл хүссэн өргөдөл, хүсэлтийг ирүүлж байна.

Хууль, журмын шинэчлэл, мэдээллийн сангийн үйл ажиллагааг нэвтрүүлэхтэй холбогдуулан газрын асуудлыг шийдвэрлэхийг түр хугацаагаар хойшлуулсан бөгөөд тус яамнаас хийсэн шалгалтын тайланг хэлэлцүүлэхтэй холбогдуулан газар ашиглах шийдвэрийг түр хугацаанд гаргахгүй байгааг дурдах нь зүйтэй.

4. Байгалийн цогцолборт газарт газар ашиглах эрх олгохдоо нутгийн ард иргэдийн саналыг авах, эрх ашиг нь хөндөгдөж болзошгүй иргэдтэй санал солилцох, сонсгол хийх зэргээр Захиргааны ерөнхий хуульд заасан зарчмыг баримтлан шийдвэрээ гаргах талаар авч байгаа арга хэмжээний тухай:

Хариулт:

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1-т "Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага Газрын тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 8 дахь хэсэгт заасан журмыг баримтлан газар ашиглах тухай хүсэлтээ хамгаалалтын захиргаа буюу хамгаалалтын захиргаа байгуулаагүй тусгай хамгаалалттай газар нутагт сум, дүүргийн Засаг даргад гаргана", 35.2-т "Хамгаалалтын захиргаа буюу Засаг дарга нь газар ашиглуулах тухай иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлт

болон түүний талаарх саналаа төрийн захиргааны төв байгууллагад уламжилна” гэж тус тус заасан.

Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаа, тухайн сум, орон нутгийн Засаг дарга нар газар ашиглуулах тухай санал ирүүлэхдээ бусдын ашиглалт, эзэмшил, өмчлөлд байгаа газартай давхцаж буй эсэхийг тодруулах, Ойн тухай, Усны тухай хуульд заасан хамгаалалтын бүсийн дэглэм, холбогдох бусад хууль тогтоомжийн хүрээнд болон MNS 5924:2015 “Нүхэн жорлон, угаадасны нүх, техникийн шаардлага”, MNS 6426:2013 “Тусгай хамгаалалттай газар нутаг дахь эко аялал жуулчлалын зориулалттай байр сууц. Үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага” зэрэг стандартыг харгалзан үзэх ёстой бөгөөд хамгаалалтын захиргаа, сум, дүүргийн Засаг даргын саналыг үндэслэн төрийн захиргааны төв байгууллагаас шийдвэр гаргадаг.

Цаашид Аялал жуулчлалын зориулалтаар газар ашиглуулахдаа тусгай хамгаалалттай газар нутгийн нөөц даацыг тогтоох, газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг боловсруулан талуудын оролцоотой менежментийн төлөвлөгөөг хамтран гаргаж хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай байгаа юм. Өөрөөр хэлбэл аялал жуулчлал хийх нэрийн дор хашааны газар олгож, тэдгээрт хэдэн гэр, байшин барьж эко гэр, буудал, жуулчны бааз байгуулан үйл ажиллагаа явуулах нь тусгай хамгаалалттай газрын хамгаалалтад авсан зорилгыг алдагдуулах, замбараагүй хашаа, байшин баригдах нөхцлийг бүрдүүлж байгаа тул үүнийг өөрчлөн тухайн бүс нутагт ямар аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар хэрэгцээт болон тохиромжтой байдлын үнэлгээ хийж ард, иргэд, дотоод гадаадын жуулчдад зориулсан нийтийн аялал жуулчлалын концепцийг төсөл сонгон шалгаруулалтын үндсэн дээр нээлттэй явуулах зарчмыг баримтлана.

5. Байгалийн цогцолборт газарт газар ашиглах эрх авсан аж ахуйн нэгж, иргэд холбогдох хууль тогтоомж, гэрээнд заасны дагуу үйл ажиллагаа явуулж буй эсэх болон түүнд тавьж байгаа хяналтын талаар:

Хариулт:

Байгаль орчин, аялал жуулчлалын сайд асан Д.Оюунхорол 2017 оны 01 дүгээр сарын 27-29-ний өдрүүдэд Хөвсгөл аймагт ажиллаж Хатгал тосгоны иргэдтэй уулзаж орон нутгийн хөгжил, байгаль хамгаалал, аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар төрөөс баримталж буй бодлого үйл ажиллагааг танилцуулж ард иргэдийн санал хүсэлтийг сонссон.

Иргэд, олон нийтийн зүгээс Хөвсгөл нуурын хамгаалалт, хог хаягдал, аялал жуулчлалын үйл ажиллагааны стандартыг боловсруулан хэрэгжүүлэх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүсийг тогтоож дэглэмийг мөрдүүлэх зэрэг газар ашиглалттай холбоотой олон асуудлыг хөндөж байсны дагуу Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Тусгай хамгаалалттай нутгийн удирдлагын газарт Хөвсгөл нуурын байгалийн цогцолборт газарт аялал жуулчлалын зориулалтаар үйл ажиллагаа явуулах эрх авсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд хяналт хийж эко стандартыг мөрдүүлэх, холбогдох чиглэлүүдээр санал боловсруулж танилцуулах үүргийг өгсөн. Энэ хүрээнд Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн А/64 дугаар тушаалаар Хөвсгөл нуурын байгалийн цогцолборт газарт аялал жуулчлалын зориулалтаар газар ашиглах зөвшөөрөл авсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын газар ашиглалтын байдалд Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай, Газрын тухай, Газрын төлбөрийн тухай, Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай, Усны тухай, Ойн тухай, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай болон холбогдох бусад хууль тогтоомж, тэдгээртэй нийцүүлэн гаргасан дүрэм, журам, стандартын хэрэгжилтэд хяналт шалгалт хийж, нэгдсэн дүгнэлт гаргах, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан бөгөөд уг ажилд дэмжлэг үзүүлэн Хөвсгөл аймгийн Засаг даргын 2017 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн А/144 дугаар захирамжаар аймгийн дэд ажлын хэсгийг байгуулан 2017 оны 03 дугаар сарын 20-28-ны өдрүүдийн хооронд тус аймгийн Мөрөн хот, Алаг-Эрдэнэ, Ханх сум, Хатгал тосгонд хамтран ажиллан холбогдох дүгнэлтийг гаргасан байна.

Хөвсгөл аймгийн аялал жуулчлалын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох, аялал жуулчлалын тогтвортой хөгжлийг хангах чиглэлээр “Тогтвортой аялал жуулчлал” форум-2017 арга хэмжээ 2017 оны 04 дүгээр сарын 15-16-ны өдрийн хооронд Мөрөн хот, Хатгал тосгонд зохион байгуулагдсан бөгөөд уг хуралд Байгаль орчин, аялал жуулчлалын яамны төлөөллийг оролцуулан ажлын хэсгийн гаргасан дүгнэлттэй холбогдуулан илтгэл тавьсан.

2017 онд хийсэн шалгалтаар дараах зөрчлүүд илэрсэн: Үүнд:

1. Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас Хөвсгөлийн байгалийн цогцолборт газарт аялал жуулчлалын зориулалтаар 118 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар ашиглах эрх олгосноос 38 жуулчны бааз улирлын чанартай тус цогцолборт газарт үйл ажиллагаа явуулж байснаас давхардсан тоогоор байгаль

орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ хийлгэсэн 42, нарийвчилсан үнэлгээ хийлгэсэн 54, нарийвчилсан үнэлгээний шаардлага хангахгүй дахин нэмэлт тодотгол хийлгэх шаардлагатай 31, байгаль орчны менежмент төлөвлөгөөг хийлгэсэн 45 иргэн, аж ахуйн нэгж, байгууллага;

2. Газрын төлбөрийн тухай хуулийн дагуу 118 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын 561.74 га газрын төлбөрт 2016 онд 44.939.200 сая төгрөг улсын төсөвт оруулахаас 42 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын 150.64 га газрын 16.431.400 төгрөг төсөвт төвлөрүүлсэн;

3. Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуулийг зөрчин газар ашиглах эрхийн гэрчилгээ болон мэдээллийн санд байх солбицлын цэгийг хэтрүүлэн талбайн хэмжээг нэмэгдүүлсэн, байрлал өөрчлөн үйл ажиллагаа явуулсан;

4. Хөвсгөл нуурын байгалийн цогцолборт газрын хил дотор орчны бүсийн сумдын Засаг дарга нарын захирамжаар өвөлжөө, хаваржаа, намаржаа, зуслан, гэр буудлын зориулалтаар 677 нэгж талбарт газар олгож, 2016 оны байдлаар Хөвсгөл нуурын байгалийн цогцолборт газар, Хатгал тосгонд 67 гэр буудлын 153 байшин, 359 гэр ажиллаж үйл ажиллагаа явуулсан байна. Асуудлыг судлан үзэхэд нутгийн иргэд өвөлжөө, хаваржаа, намаржаа, зуслангийн зориулалтаар газар ашиглаж байна уу гэхэд орон нутгийн харьяалалгүй, харьяалалттай байсан ч гэсэн зориулалт өөрчлөн аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулж байгаа нь Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийг зөрчиж байгаа юм. Тодруулбал эдгээр гэр буудал, жуулчны баазууд нь ус ашигласны ашиглалтын төлбөр төлдөггүй, байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий болон нарийвчилсан үнэлгээг хийлгэж эрх бүхий субъектээр батлуулаагүй, нэвчилттэй энгийн нүхэн жорлонтой үйл ажиллагаа явуулж байсан.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны зүгээс Хөвсгөл нуурын байгалийн цогцолборт газарт аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулах эрх авсан боловч холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын судалгааг үе шаттайгаар гарган газар ашиглах эрхийг цуцлах бодлого баримтлан ажиллаж байна. Тухайлбал Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн А/89 дугаар тушаалаар 12 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын 45.24 га газрын эрхийг дуусгавар болгосон. Дээрх хяналт шалгалттай холбоотойгоор Хөвсгөл аймгийн Засаг дарга Л.Ганболдод 2017 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн 01/2541 тоот албан бичгийг хүргүүлж дараах чиглэлийг хүргүүлж байсан. Үүнд:

1. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэгт заасны дагуу онцгой бүсэд өвөлжөө, хаваржаа, намаржаа, зуслангийн барилга байгууламж барьсан судалгааг гаргаж Хөвсгөл нуурын байгалийн цогцолборт газарт орон нутгаас өвөлжөө, хаваржаа, намаржаа, зуслангийн зориулалтаар олгосон газруудын эрхийг цуцлуулах талаар сумдын Засаг дарга нарт шаардлага хүргүүлж Газрын тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1-т заасан арга хэмжээг авах;

2. Өвөлжөө, хаваржаа, намаржаа, зуслангийн зориулалтаар газар ашиглах эрх авсан боловч гэр буудлын үйл ажиллагаа явуулж байгаа аймгийн болон бусад орон нутгийн иргэдийн судалгааг сумдын Засаг дарга нараас гаргуулан гэр буудлуудыг Хөвсгөл нуурын байгалийн цогцолборт газарт байрлуулахгүй байх, газар ашиглах эрхийг цуцлуулах, гэр буудлууд байх шаардлагатай гэж үзвэл уламжлалт нүүдлийн соёл, мал аж ахуй, нутгийн иргэдийн амьдралын хэв маягийг харуулсан байдлаар, нэгдсэн нэг газарт төвлөрүүлж, гэрээ байгуулан ажиллах;

3. Аялал жуулчлалын улиралд Хатгал тосгоны усан зогсоолын эцэст автомашины бөөгнөрөл их болдог, мөсний баярын үйл ажиллагааны үеэр нуурын мөсөн дээр олон тооны автомашин, техник хэрэгсэл зогсоодог, замбараагүй зорчдог байдлыг болиулж нэгдсэн зогсоолын газрын асуудлыг шийдвэрлэх чиглэлийг өгсөн байдаг.

Тус шалгалтыг өвөлийн улиралд хийсэн бөгөөд зун жуулчны баазууд, гэр буудлуудыг үйл ажиллагаа явуулахад дахин хяналт шалгалт хийх нь зүйтэй гэж үзсэн.

Ингээд Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны 08 дугаар сарын 09-ний өдрийн А/275 дугаар тушаалаар

Төрийн нарийн бичгийн даргын 2018 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн А/366 дугаар тушаалаар Хөвсгөл аймагт ажиллах ажлын хэсгийн удирдамжийг гаргуулан дэд сайдаар ахлуулан 2018 оны 08 дугаар сарын 16-24-ний өдрүүдэд хяналт шалгалтыг дахин хийлгэсэн. Шалгалтын дүн мэдээг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шаардлагатай арга хэмжээг авч холбогдох албаны хүмүүст хариуцлага тооцон ажиллах болно.

Шалгалтаар дараах дүгнэлт гарсан. Үүнд:

1. Хөвсгөл нуур орчмын аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудаас БОАЖ-ын сайдын тушаалаар олгогдсон

зөвшөөрөлтэй 54, зохих зөвшөөрөлгүй бааз, гэр буудал ажиллуулж байгаа 72, тусгай хамгаалалттай газраас гадна сум орон нутгаас олгогдсон 16 байна.

2. Хөвсгөл нуурын байгалийн цогцолборт газарт орон нутгийн хэмжээнд 677 өвөлжөө хаваржааны зориулалтаар газар олголт хийсэн байна. Гэтэл энэхүү газруудад гэр баазуудыг байгуулж, аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа нь хамгийн их хууль зөрчсөн асуудал үүсгэж байна.

3. Зөвшөөрөлгүй гэр буудлуудыг татан буулгах, эрүүл ахуйн шаардлагад тавигдах стандарт дүрэм журмын хэрэгжилтийг хангаж ажиллах, Усны тухай хууль, жуулчны бааз, гэр буудалд тавигдах ерөнхий шаардлага, ТХГН-т мөрдөгддөг дүрэм журам, стандартын хэргэжилтийг хангаж ажиллах. Үүний хүрээнд сургалт сурталчилгаа, хэрэгжилт, хяналтыг бүх шатны төрийн байгууллага, хувь хүн хэрэгжүүлж ажиллах шаардлагатай.

4. Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын нутаг дэвсгэрт Хөвсгөл нуурыг тойрон үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ-ын хог хаягдлын нэгдсэн цэгт ангилан ялгах арга хэмжээ авдаггүй, тусгайлан гаргаж өгсөн нэгдсэн хогийн цэг дүүрсэн, хог хаягдлыг булж устгадаггүй, хөрсийг бохирдлоос хамгаалах арга хэмжээ аваагүй, метан зайлуулах агааржуулалтын хоолойгүйн улмаас байнгын шаталт үүсэх магадлалтай байдгаас орчны агаар, хөрс болон усыг бохирдуулах нөхцөл бүрдсэн байна.

5. Хатгал тосгон дахь Хөвсгөл нуур орчмын жуулчны баазуудын нэгдсэн цэвэрлэх байгууламж нийт 2 карттай, тус эзэмшлийн газарт нэмж карт барьж өргөтгөх боломжгүй, хяналтын цооног байхгүй, аваарыг картгүй нь бохир усны цэвэрлэгээ стандартын хэмжээнд цэвэрлэгдэхгүй картанд хаягдаж бохир ус газрын хөрсөнд шингэж хөрс, газар доорхи усыг бохирдуулж улмаар хүний амь нас, байгаль орчинд сөргөөр нөлөөлөх, хөрс болон усаар дамжин халдварлах халдварт өвчин үүсгэх боломжийг бүрдүүлсэн байна.

6. Нуурын орчимд аялал жуулчлалын зориулалтаар газар ашиглаж байгаа аж ахуйн нэгжүүд, гэр буудлууд нь зөвшөөрөлгүй хашаагаа сунгаж, нуурын хамгаалалтын бүсэд барилга байшин барьсан зэрэг зөрчлүүд илэрсэн.

7. Мэдээллийн санд зарим иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын кадастрын зураг алдаатай, талбай хэмжээ хэтрэлттэй байна. Энэ нь проекц болон геодезийн эхлэл цэгийг буруу өгснөөс болон хамгаалалтын захиргааны мэдээллийн сангийн үйл ажиллагаа учир дутагдалтай, чанарын шаардлага хангахгүй байна.

8. Тусгай хамгаалалттай газарт газар ашиглах эрх авсан иргэн, хуулийн этгээдийн газар ашиглах гуравласан гэрээний дагуу хүлээсэн үүргийн биелэлтэнд хяналт шалгалт хийж гэрээг жил бүр дүгнэхгүй байна.

9. Ус ашиглах гэрээ, ус ашиглуулах дүгнэлт нь тооцоолол судалгаа байхгүй хийсвэр хийгдсэнээс усны төлбөр бодитой төлөгдөхгүй байна, "Усны тухай" 30 дугаар зүйлийн 30.1.4-д заасны дагуу Ус ашиглагч нь "ус авах цэг, газар доорх усны цооног, шугам хоолой бүрийг тоолууржуулах" зэрэг ажилд хангалтгүй байгаа нь аймгийн БОАЖГ, Мэргэжлийн хяналтын газар, Сав газрын захиргаа, Хөвсгөл нуурын УТХГ-ын хамгаалалтын захиргаа, орон нутгаас тавих хяналт хангалтгүй, уялдаа холбоогүй байгаатай холбоотой.

10. Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээнд нэмэлт тодотгол хийгддэггүй, тухайн жилийн Байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг батлуулж тайлагнадаггүй, түүнд хяналт тавьдаггүй нь Хөвсгөл нуур, түүний эрэг орчмын экосистемийн өөрчлөлтөд урт болон богино хугацааны мониторинг хийх боломжгүй байна.

11. Байгалийн цогцолборт газрын хэмжээнд хог хаягдлын менежмент сайжирч, нэгдсэн зохион байгуулалтад орсон байна.

12. БОАЖ-ын сайдын 2017 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн "Нүхэн жорлонг хориглох тухай" А/73 дугаар тушаал, төслийн хүрээнд жуулчны баазуудад сургалт зохион байгуулсан нь үр дүнтэй болж ААН-ийн ариун цэврийн байгууламжууд шинэчлэгдсэн байна.

13. Орон нутгийн байгаль орчны байцаагч, газрын даамал, аялал жуулчлал хариуцсан мэргэжилтэн нарын хууль эрх зүйн мэдлэг болон ажлын хариуцлага сул, эргэх холбоо муу байна.

14. Нуурын экосистем орчин ашиглалт, ус ашиглалт, эргийн хамгаалалт, бүсийн дэглэм мөрдөгдөх асуудлууд сул, хууль журмын хэрэгжилт хангалтгүй.

15. Усан тээврийн хэрэгсэл тогтмол тээвэр хийдэг байна. Гэтэл усан тээврийн хэрэгслийг зогсоох шаардлага хангасан зориулалтын авто тээврийн зогсоол байхгүй байгаа нь нуурын усанд бензин шатахуун асгах зэргээр бохирдуулах эх үүсвэр болоод байна.

ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ САНАЛ

БОАЖЯ

Усны чиглэлээр:

1. Орон нутгийн БОАЖГ-т Усны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар хугацаатай үүрэг, чиглэл өгөх. Ялангуяа Усны нөөц ашигласны төлбөрийн орлогыг бодитой болгох;

2. Жуулчдын оруулж ирж байгаа хийлдэг болон моторт завь, квадроцикл, мотокросс мотоциклоос хураамж авдаг болох тусгайлсан журам боловсруулах; /Хураамжийн орлогыг эргүүлийн завины шатахуун, арчилгаа, байцаагч нарын цалинд зарцуулахыг зааж өгөх/

Аялал жуулчлалын чиглэлээр:

1. Жуулчны бааз, гэр буудал, резортуудын үйлчилгээний ялгааг тусгасан стандартуудыг тус тусад нь боловсруулж, батлуулах, мөрдүүлэх;

2. Жуулчны бааз, резортын хоолны үйлчилгээнд эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагууд тэр дундаа зориулалтын угаалгын шингэн, автомат угаалгын машин, ариутгагчтай хатаагч хэрэглэх талаар тусгах;

3. ХНБЦГ-ын аялал жуулчлалын нөөц, даацын судалгааг шинээр хийж, судалгааны үр дүнд үндэслэсэн аялал жуулчлалын менежментийн төлөвлөгөөг мөрдүүлэх;

4. Шинээр боловсруулсан гэр буудлын стандартыг таниулах, мөрдүүлэх ажлыг орон нутгийн түвшинд шат дараатай зохион байгуулах;

5. Үйлчилгээний чанарыг сайжруулах, үйлчилгээний ажилтнуудыг бэлтгэхэд чиглэсэн сургалтуудыг тогтмол хугацаанд зохион байгуулах;

6. Усан орчин ашиглалттай холбоотойгоор БОАЖЯ, Зам тээврийн яам, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар хамтран хийлдэг болон моторт завь, бартаат замын мотоциклийн ашиглалтын талаар журам гарган хэрэгжүүлэх;

7. Ханх сумыг олон улсын аялал жуулчлалын бүс болгох төслийн санал боловсруулах;

Тусгай хамгаалалтын чиглэлээр:

1. Мэдээллийн сангийн газрын координат, зураглал, хэмжилтийг дахин хянан үзэж, зөрчлийг арилгах арга хэмжээг зохион байгуулах;

2. Тусгай хамгаалалттай газарт аялал жуулчлалын зориулалттай газар ашиглах гуравласан гэрээг жил бүр дүгнэх загвар хуудсыг бий болгох;

3. Ажлын хэсгээс гаргасан дүгнэлтийн дагуу 2019 оны 2 дугаар улирлаас хэрэгжиж эхлэх Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй 19 сая ам долларын төслөөс Ханх сум, Хатгал тосгоны эдэлбэр газрын хатуу хог хаягдлын цэгийг сайжруулан орчин үеийн ландфилийн аргын хогийн цэг болгож шинэчлэх, Бохир ус цэвэрлэх байгууламжийг шинэчлэн барьж байгуулах ажлыг тусгаж оруулах;

4. Нууран дахь эргүүл хяналт шалгалтыг сайжруулах 6-10 хүний суудалтай эргүүл хийх моторт завьтай болох;

5. “Тусгай хамгаалалттай газар нутагт аялал жуулчлалын үйл ажиллагаанаас байгалт орчинд нөлөөлөх байдлыг шалгах хяналтын хуудас”-д аялал жуулчлалын стандарт болон ариун цэврийн байгууламжийн технологийн талаар нэмэлт өөрчлөлт оруулах;

6. Холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, стандартын сургалт, сурталчилгааг жилдээ нэг зохион байгуулж хэрэгжилтийг тайлангаар авч хянадаг байх.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний чиглэлээр:

1. Тусгай хамгаалалттай газар нутаг дахь аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулж буй иргэн, ААНБ-ын Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий болон нарийвчилсан үнэлгээний тайлан нь бусад хууль тогтоомжтой нийцэж байгаа эсэхэд хяналт тавих;

2. Тухайн жилийн Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг батлан, тайланг хянах зохицуулалтыг тодорхой болгож, нэгдсэн сан бий болгох;

Ариун цэврийн байгууламжийн чиглэлээр:

1. Ариун цэврийн байгууламжыг стандартын дагуу шинэчлэх;

2. ОХУ-аас ирж байгаа завины ариутгал, халдваргүйжилтийг Хилийн Мэргэжлийн Хяналтын албанд тодорхой чиглэл өгч хариуцуулах;

3. Ханх суман дахь Хөвсгөл нуурын эргээс нүүлгэх шаардлагатай төрийн байгууллагуудын барилга, байгууламжуудын зардлыг шийдвэрлэх;

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗД. БОАЖГ-Т

1. Хөвсгөлийн БЦГ-т орон нутгаас олгогдсон өвөлжөө хаваржаа, эзэмших зориулалттай газруудыг цэгцлэх, нэгдсэн арга хэмжээ зохион байгуулах;

2. Гэр буудал, баазуудад аялалын жуулчлалын нэгдсэн стандарт мөрдүүлж ажиллах;

3. Усны тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан журам, дүрмийн хэрэгжилтийг чангатгах, бүсийн дэглэмийг хатуу мөрдүүлэх;

4. Байгаль орчны чиглэлийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах, хамтын ажиллагаагаа уялдуулах, хамтран ажиллах;

5. Нуур орчмын сумын эдэлбэрт хамрагдаж байгаа газарт аялал жуулчлалын зориулалттай газар олгохдоо Усны тухай, Ойн тухай хуулийг мөрдлөг болгох;

6. 1994 оны УИХ-ын тогтоолоор Хөвсгөл нуурын хил Ханх суманд харьяалагддаг бөгөөд усны нөөц ашигласны төлбөрийн орлогыг Ханх суманд төвлөрүүлдэг болохыг судалж үзэх;

7. Хог хаягдлын машин, тусгайлсан байцаагчтай болох;

8. Орон нутгийн онцлогийг харгалзан байгаль хамгаалах чиглэлийн мэргэжилтнүүдийн ахуй хангамж, мэдлэг чадварыг дээшлүүлэх тал дээр анхаарах;

9. Усны нөөц ашигласны төлбөрийг Усны тухай хуульд нийцүүлэн тоолуурын дагуу ашигласан усны хэмжээгээр тогтоож, бэлэн мөнгөөр авахгүй байх,

10. Ус ашиглах гэрээ, дүгнэлтийг Усны тухай хуульд нийцүүлэн гаргах, үүнд тавих хяналтыг сайжруулах,

11. Тамга тэмдэг, баталсан дүрэм журамгүйгээр хувийн хэвшлийнхэнд дарамт үзүүлэхгүй ажиллах.

ХӨВСГӨЛ НУУРЫН УТХГ-ЫН ХАМГААЛАЛТЫН ЗАХИРГААНД

1. Гэр буудлуудад аялал жуулчлалын стандартын хэрэгжилтийг хангуулж ажиллах;

2. Малчин иргэдийн болон малын тоо толгойн судалгааг боломжит жил бүрээр түүхчлэн гаргаж мал бэлчээхгүй, малтай өрхийг цогцолборт газрын онцгой бүсээс гаргах, тэнцвэрт байдлыг хангах талаар санал боловсруулах;

3. Хөвсгөлийн БЦГ-т аялал жуулчлалын зориулалтаар үйл ажиллагаа явуулах эрх авсан иргэн, хуулийн этгээдийн ашиглаж буй газрын хяналтын хэмжилтийг аймгийн Засаг даргатай хамтран дахин хийж тушаал шийдвэр, талбайн хэмжээтэй тулган нэгдсэн шийдвэр гаргах;

4. Хөвсгөл аймгийн байгалийн цогцолборт газарт амьдарч буй ард иргэд, аж ахуйн нэгж байгууллага, жуулчид бүгд нуурын уснаас ундаалдаг. Иймд нуурын усны цэвэр цэнгэг байдал нь хүн амын эрүүл аюулгүй амьдрахтай шууд хамааралтай тул нуурын усны эрүүл ахуйн хамгаалалтын бүсийг Усны тухай хуулийн 11.1.4-т заасны дагуу тогтоож, дэглэмийг мөрдүүлэх шаардлагатай байна.

5. Бичиг баримтын бүрдэл хангалтгүй, зөрчилтэй иргэн, ААНБ-д хугацаатай албан шаардлага хүргүүлэх, биелүүлж ажиллаагүй тохиолдолд үйл ажиллагааг зогсоох;

6. Аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулж байгаа ААН-ийг хүчин чадлаас нь хамааруулж зэрэглэл тогтоож шаардлагыг хангуулах;

7. Аялал жуулчлалын зам, маршрутыг чиглэл тус бүрээр талуудын оролцоотой боловсруулан газарзүйн мэдээллийн системийн програм хангамжид зураглах, танилцуулга мэдээллийг боловсруулан сайдын тушаалаар батлуулах, маршрут дагуух тохижилтийн ажлын зардлын тооцоо, зураглалыг яаралтай гаргах;

8. Мөсний баярыг тэмдэглэхдээ нуурын мөсөн дээр олон тооны тээврийн хэрэгслийг зогсоохгүй байх, нуурын эрэг дээр нэгдсэн автозогсоолыг төлөвлөх;

9. Усны онцгой бүс, усан зам ашиглалт, галын аюулгүй байдлын талаар дагаж мөрдөх журам дүрмийг чандлан сахиулах;

10. Байгаль орчны багц хууль тогтоомж болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан журам, дүрмийн хэрэгжилтийг чангатгах, бүсийн дэглэмийг хатуу мөрдүүлэх;

11. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хөтөлбөрт тусгагдсан ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах;

12. Хөвсгөл нуурын орчны бүсэд машин болон дотоод гадаадын иргэдийг нэвтрүүлэхгүй байх, далан шуудуу болон өнгө үзэмжтэй шонгууд суулгах;

13. Жанхайн даваан дээр улирлын чанартай пост ажиллуулах. Энэхүү пост нь хүн тээврийн автомашинд хяналт тавихгүй, зөвхөн ачааны машинд (гэр ачсан) хяналт тавьж, зөвшөөрөлгүй буух гэр буудлуудын үйл ажиллагааг нь хязгаарлана.

САВ ГАЗРЫН ЗАХИРГААНД

1. Аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, ААНБ-ын ус ашиглалтыг тоолууржуулж, ундны усны стандартын хэрэгжилтийг хангуулах;

2. БОМТ, ОХШ-ний хөтөлбөрт тусгагдсан усны чанарын шинжилгээний дүнг нэгтгэн дүн шинжилгээ хийж хэвших;

3. Усан сан бүхий газрын бүсийн дэглэм, усан зам ашиглалт, галын аюулгүй байдлын талаар дагаж мөрдөх дүрэм, журмыг чандлан сахиулах;

4. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;

5. Хөвсгөл нуурыг хамгаалах, усны зохистой ашиглалтын талаар сургалт сурталчилгааг дотоод, гадаадын амрагч аялагч нарт тогтмол хийж байх;

АЙМГИЙН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗАРТ

1. Аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулж буй иргэн, ААНБ-уудад жил бүр нэгдсэн хяналт шалгалтыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулж, гүйцэтгэлийг хангуулан зөвлөн туслах.

6. Цаашид Хөвсгөл аймаг дахь байгалийн цогцолборт болон дархан цаазат газрын талаар хэрэгжүүлэх арга хэмжээ, төлөвлөсөн ажлын талаар:

Хариулт:

Хүний нөөцийн чиглэлээр:

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн даргын баталсан удирдамжийн дагуу Хөвсгөл нуурын улсын тусгай хамгаалаттай газрын хамгаалалтын захиргааны дарга, мэргэжилтэн, байгаль хамгаалалгчдын ажлын явцыг шалгах, зөвлөмж өгөх, нэгдсэн дүгнэлт гаргах зорилгоор 2018 оны 10 дугаар сарын 22-24-ний өдрүүдэд тус яамны Тусгай хамгаалаттай нутгийн удирдлагын газрын ахлах мэргэжилтнүүд ажилласан. Шалгалтаар тус захиргаанд ажиллаж байгаа мэргэжилтнүүдийг сэлгэн ажиллуулах, газар ашиглалт, аялал жуулчлалттай холбоотой асуудлыг мэргэжлийн хүнд /инженерийн түвшинд ажиллах/ хариуцуулах, нээлттэй сонгон шалгаруулалт зарлах шаардлагтай гэсэн дүгнэлт гарсан. Үүнтэй холбоотойгоор хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэх;

Хяналт шалгалтын чиглэлээр:

Хөвсгөл нуурын байгалийн цогцолборт газарт хийсэн шалгалттай холбоотой асуудлаар чиглэл тус бүрээр шат дараалсан арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

Төсөл, хөтөлбөр, хөрөнгө оруулалтын хүрээнд:

Монгол Улсын тусгай хамгаалалттай газар нутагт оршин суудаг ард иргэдийн амьжиргаа, аялал жуулчлал, хог хаягдлын менежментийн асуудлуудыг нэгдсэн байдлаар авч үзэж нутгийн иргэдийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэн, амьжиргааны түвшинг дээшлүүлэх зорилгоор Ядуурлыг Бууруулах Японы сангийн 3,0 сая ам.долларын буцалтгүй тусламжаар “Хөвсгөл нуурын байгалийн цогцолборт газрын орчны бүсийн иргэдийн амьжиргааг дэмжих, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх нэгдсэн төсөл”-ийг Байгаль орчин аялал жуулчлалын яам, Азийн хөгжлийн

банк хамтран Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ, Чандмань-Өндөр, Цагаан-Үүр, Ренчинлхүмбэ, Ханх сумд, Хатгал тосгонд 2016-2019 онд хэрэгжүүлж байна.

Энэ төслийн хүрээнд:

✓ “ХНБЦГ-т аялагчид дагаж мөрдөх ёс зүйн дүрэм” –ийг боловсруулж, Хөвсгөл аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээр хэлэлцүүлэн 109-р тогтоолоор батлуулан олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, нийгмийн сүлжээ, ХУТХГ-ын нэвтрэх цэгүүд, жуулчны баазууд, гэр буудлаар дамжуулан сурталчилж байна. 2017 оны 6 дугаар сарын эцсийн байдлаар ХНБЦГ-т зөвшөөрөлтэй идэвхитэй үйл ажиллагаа явуулдаг 44 жуулчны баазаас 23 жуулчны бааз (52%), 31 гэр буудлаас 12 гэр буудал (39%) эрхлэгчдийн төлөөлөл, 12 гар урлалын бүтээгдэхүүн худалдаалдаг иргэд, завь болон хөтчийн үйлчилгээ эрхлэгчдийн төлөөлөл ёс дүрэмтэй танилцан гарын үсэг зурж үйл ажиллагаандаа хэрэгжүүлж эхэлснээр нүхэн жорлонгоо солих, шинэчлэх, мөн аялагч амрагчдын хог хаяхгүй байх ухамсар дээшлэх зэрэг эерэг үр дүнгүүд гарч байна. Иймд Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас Монгол Улсын хэмжээнд аялал жуулчлалын ёс дүрэмтэй болох, тусгай хамгаалалттай бусад газруудад уг туршлагыг нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах боломжтой.

✓ Төслийн зүгээс нутгийн иргэдийн аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг дэмжих зорилгоор төслийн мэргэжилтнүүд, Шинэ Зеландын TRC аялал жуулчлалын зөвлөх компани загвар байдлаар боловсруулан хэрэгжүүлж буй “Эко аялал жуулчлалын сургалтын хөтөлбөр”-ийн хүрээнд тусгай хамгаалалттай газрын менежмент, гэр буудлын стандарт, угтах зочлох үйлчилгээ, нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлэх боломж, орон нутгийн түүхий эдээр төрөл бүрийн гар урлалын бүтээгдэхүүн үйлдвэрлэх, морин хөтчийн болон хүлэмж барих, хүнсний ногоо тариалах зэрэг 14 удаагийн дадлага сургалтад нийт 503 хүн хамрагдсан. Цаашид энэхүү хөтөлбөрийн дагуу 2019 онд төсөл хэрэгжүүлж буй сум, тосгонд сургалтыг үргэлжлүүлэн зохион байгуулна. Мөн тусгай хамгаалалттай бусад газарт нутгийн иргэдийн ур чадварыг сайжруулах сургалтыг энэхүү загвараар зохион байгуулах боломжтой.

✓ Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлэх, аялал жуулчлалын улирлын хамаарлыг бууруулах, төслийн сумдыг дамнасан аялал жуулчлалын бүтээгдэхүүн бий болгох зорилгоор “Даян дээрхийн шагайн харваа наадам”, “Цас, цааны баяр” аялал жуулчлалын эвентийг шинээр зохион байгуулж, “Морин аялалын маршрут” гаргах, “Алунгуа хатны сургаалийн баяр”, “Сарлагийн баяр”, “Мөсний баяр” зэрэг эвентийг ивээн тэтгэж оролцож байна. Энэ мэтээр

цаашид эвент арга хэмжээнд нутгийн иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, тэдний бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарыг сайжруулах замаар орлогоо нэмэгдүүлэх боломжийг ханган ажиллана.

✓ Хөвсгөл нуурын байгалийн цогцолборт газрын орчны бүсийн иргэдийн амьжиргааг дэмжих зорилгоор Хөвсгөл нуурын байгалийн цогцолборт газрын орчны бүсийн нутгийн иргэдийн удирдлагатай зээлийн эргэлтийн санг ашиглах захиран зарцуулах журмыг боловсруулан батлуулж, 5 сум, 1 тосгонд нутгийн иргэдийн удирдлагатай зээлийн эргэлтийн сан байгуулав. (Хатгал тосгон -120,000 ам.доллар; Ханх сум -100,000 ам.доллар; Алаг-Эрдэнэ, Чандмань-Өндөр, Цагаан-Үүр, Рэнчинлхүмбэ сумд тус бүр 75,000 ам доллар, нийт 520,000 ам доллар) Зээлийн эргэлтийн сангийн эхний удаагийн санхүүжилт болох нийт 57,000 ам.доллар буюу сан тус бүрт 9500 ам.долларыг 2017 оны 04 дүгээр сард, 2 удаагийн санхүүжилтийн эхний хэсэг болох 150,000 ам.долларыг 2018 оны 04 сард, 2 дахь хэсэг болох 210,000 ам долларыг 2018 оны 10 дугаар сард 6 санд тус тус шилжүүлэв.

✓ Улмаар Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ, Чандмань-Өндөр, Цагаан-Үүр, Рэнчинлхүмбэ, Ханх сумд болон Хатгал тосгоны нутгийн иргэдийн удирдлагатай зээлийн эргэлтийн сангаас 2018 оны 10 дугаар сарын 31-ний байдлаар нийт 148 төсөлд нийт 698,5 сая төгрөгийн зээлийг аялал, жуулчлал, мал аж ахуйн чиглэлээрх өрхийн бичил бизнесийг дэмжихэд зориулан олгож нийт 201 ажлын байр шинээр бий болгов. 2018 оны 11 дүгээр сард багтан 210,000 ам. долларын эх үүсвэрээр зээл олгох бөгөөд ингэснээр зээлийн эргэлтийн санд нийт 1,237,280,000 төгрөгийн эх үүсвэр эргэлтэд орох бөгөөд 2019 оны эхээр 103,000 ам долларын эх үүсвэр буюу сангийн 3 удаагийн санхүүжилтийг бүрэн олгохоор төлөвлөж байна.

✓ Төслийн багаас зээлийн эргэлтийн сангийн үйл ажиллагаа, зээл олголт, эргэн төлөлтөд байнгын хяналт мониторинг хийхийн зэрэгцээ ЗЭС-ийн хороо, сангийн менежерийг чадавхижуулах сургалтыг 2017, 2018 онд тус тус зохион байгуулав. Мөн цаашид эргэлтийн санг тогтвортой ажиллуулахын тулд стратеги боловсруулах судалгааны ажлыг хийж 2019 онд зээлийн эргэлтийн сангуудыг хууль эрх зүйн чадамжтай, тогтвортой үйл ажиллагаатай орон нутгийн бичил санхүүгийн байгууллага болгох шинэчлэн зохион байгуулах ажлыг хийж туршлагаа хуваалцах болно.

✓ Орчны бүсийн 5 сум, 1 тосгоны 157 өрхийг оролцуулсан 23 малчны бүлэг байгуулан мэргэжлийн зөвлөхийн удирдлага дор малчдын бүлэг, ХУТХГ, багийн дарга, сумын газрын даамал зэрэг талуудыг оролцуулан бэлчээрийн нөөц,

даацын мониторинг судалгааг хийж, улмаар судалгааны дүнд үндэслэн малчдын бүлэг бүрээр бэлчээрийн менежментийн төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж байна. Мөн 2018 онд цогцолборт газрын бэлчээр ашиглалтын нэгдсэн төлөвлөгөөг боловсруулан 2019 оноос хэрэгжүүлж эхлэх бөгөөд ингэснээр нуур орчмын бэлчээрийг хамгаалах, зохистой ашиглах боломж бүрдэнэ.

✓ Сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах, зөгийн аж ахуй эрхлэх, ногоо, жимс даршлах, ноосоор бүтээгдэхүүн хий, сарлагын хөөвөр самнах, ангилах, малын эрүүл мэнд, мал үржил, малын тэжээл тариалах, байгалийн өвс, халгайгаар дарш хийх, бэлчээрийн мониторинг хийх, байгаль орчны манлайлал, эргэлтийн сангийн зээлийн төсөл боловсруулах, ариун цэврийн байгууламж барих зэрэг 25 удаагийн сургалтад нийт 2189 иргэн хамрагдав. 2019 онд дээр сэдвээр ахисан түвшний дадлага сургалтуудыг үргэлжлүүлэн зохион байгуулна.

✓ Хөвсгөл нуурын усны чанарыг шинжлэх ухааны үндэслэлтэй тогтоох, байнга хянах, цаашид тогтвортой үргэлжлүүлэн хэрэгжүүлэх стратегийг боловсруулах зорилгоор “Нуурын усны чанарын хяналтын хөтөлбөр” боловсруулан ажлыг 2017 оны 03 дугаар сараас Байгаль орчны зөвлөх үйлчилгээний “Нэйчрал Састайнэблэ” ХХК гүйцэтгэж 2 жил дараалан судалгаа хийж байна. Үүний үр дүнд мэдээллийн бааз бүрдүүлэх, цаашид усны чанарыг тогтмол хянах судалгааны арга зүй, түүнийг ашиглах гарын авлага боловсруулах, судалгааны ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх байгууллагын чадавхыг үнэлэх, мэргэжилтнүүдийг сургах зэрэг ажлыг зохион байгуулж байгаа бөгөөд 2019 онд судалгааны эцсийн тайланг БОАЖЯ хүлээн авч нуурын усны чанарыг тогтмол хянах ажил хийгдэнэ.

✓ Хог хаягдлын менежментийн хөтөлбөрийн хүрээнд 5 сум, 1 тосгонд нийт 28 хүний бүрэлдэхүүнтэй нутгийн иргэдийн 8 бүлэг цогцолборт газар болон төсөл хэрэгжиж буй сумдын хатуу хог хаягдлын менежментийг хариуцан ажилласнаар эзэнгүй болон хур хог хаягдал буурч байна. Эдгээр хог хаягдлын бүлгүүдэд өвөл, зуны зуны иж бүрэн ажлын хувцас, малгай, бээлий, маск, хүрз, тросон шүүр, хогийн хавчаар, багажны сав, чанга яригч, ус шүршигч зэрэг хэрэгсэл, багажуудыг төслөөс хүлээлгэн өгч тэдний үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлснээр байнгын 10, улирлын чанартай 18 ажлын байр бий болгосон. Ингэснээр тусгай хамгаалалттай газар нутагт оршин суудаг иргэд байгаль хамгаалах үйлсэд гар бие оролцохын зэрэгцээ ажилтай, орлоготой болох сайн туршлага, загвар болж байгаа бөгөөд төсөл дууссаны дараа энэхүү бүлгүүдийн санхүүжилтийг орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлэхээр тохиролцоод байгаа болно. Монгол

